



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/29/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: dolgorsuren.b@audit.gov.mn Аудитор: Ж.Мөнхтуул Утас: 261740 Цахим хаяг: munkhtuul.j@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эйч Эл Би Монголиа Аудит ХХК Захирал: Ч.Энхтуяа Цахим хаяг: enkhtuya@hlb.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХАРИУ АРГА
ХЭМЖЭЭ АВАХ НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТӨСӨЛ 2-ЫН
ЗОХИЦУУЛАГЧ Ц.БОЛОРМАА ТАНАА

2024.02.29 № 07/602
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн Газар, Азийн Хөгжлийн банкттай 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрээр "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2"-ыг хэрэгжүүлэхэд АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжих 46,400.0 мянган ам.долларын 4052-МОН дугаар энгийн зээл, 26,600.0 мянган ам.долларын 4051-МОН дугаар хөнгөлөлттэй зээлийг олгохоор болсон байна.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр дээрх зээлийг соёрхон баталсан бөгөөд тус төсөл 2024 оны 08 дугаар сарын 31-ний өдөр хэрэгжиж дуусах бөгөөд АХБ-ны 73,000.0 мянган ам.долларын зээл, Монгол Улсын Засгийн газрын 186,640.0 мянган ам.доллар санхүүжилтийг авч, нийт 259,640.0 мянган ам.доллаароор санхүүжүүлэхээр байна.

Аудитын гол асуудал

Азийн Хөгжлийн Банкны зээлийн хөрөнгөөр Нийгмийн халамжийн хөтөлбөрийг цахимжуулах мэдээллийн сангийн тоног төхөөрөмж, программ хангамж нийлүүлэх ажлын хүрээнд худалдан авсан 3,194,803.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/08 дугаар тушаалаар хүлээлгэн өгсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2 нь 2023 онд 5,569,598.2 мянган төгрөгийн гадаад зээл авч, шинэчилсэн Орлогыг орлуулан тооцох аргачлалаар хийх судалгааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх замаар бодит хэрэгцээтэй иргэдэд хүрч үйлчлэх үүднээс зорилтот бүлгийг тогтоох систем болон өрхийн мэдээллийн нэгдсэн системийг илүү нарийвчилсан өгөгдлөөр шинэчлэх, Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг “ehalamj” системд холбож, тэтгэмж, үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай болгох, Зорилтот өрхийн амьжиргааг сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ бүхий, төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр нөлөөний үнэлгээ хийх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,021,229,550.29	2,574,739,765.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,463,283,715.63	2,506,956,212.58
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	1,463,283,715.63	2,506,956,212.58
31210	Төгрөг	247,576,352.97	1,725,204,031.52
31211	Төрийн сангийн харилцах	247,576,352.97	1,725,204,031.52
31220	Гадаад валют	1,215,707,362.66	781,752,181.06
31221	Төрийн сангийн харилцах	1,215,707,362.66	781,752,181.06
33	АВЛАГА	151,422.86	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
33103	Татварын авлага	151,422.86	-
34	УРЬДЧИЛГАА	2,555,842,432.80	10,637,447.00
34600	Урьдчилж гарсан зардал	2,555,842,432.80	10,637,447.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,951,979.00	8,630,379.00
35400	Хангамжийн материал	1,951,979.00	8,630,379.00
35420	Аж ахуйн материал	1,951,979.00	8,630,379.00
36	Бусад эргэлтийн хөрөнгө	-	48,515,727.27
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	-	48,515,727.27
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,021,229,550.29	2,574,739,765.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	93,803.82	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	93,803.82	-
41300	Өглөг	93,803.82	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	93,803.82	-
41360	Бусад өглөг	-	-
41363	Татварын өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,021,135,746.47	2,574,739,765.85
51	Засгийн газрын хувь оролцоо	4,021,135,746.47	2,574,739,765.85
51200	Хуримтлагдсан үр дүн	4,021,135,746.47	2,574,739,765.85
51210	Өмнөх үеийн үр дүн	1,265,402,764.84	4,021,135,746.47
51220	Тайлант үеийн үр дүн	2,755,732,981.63	(1,446,395,980.62)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,021,229,550.29	2,574,739,765.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	86,367,904,185.64	6,031,771,969.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,367,904,185.64	6,031,771,969.30
120	Нийтлэг татварын бус орлого	86,367,904,185.64	6,031,771,969.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	86,367,904,185.64	6,031,771,969.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	86,014,682,654.15	4,921,407,096.13
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих /шууд төлбөр/	-	638,960,608.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	353,021,531.49	471,404,264.97
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	83,782,537,861.71	7,498,908,531.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,429,458,711.18	4,304,177,490.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	83,429,458,711.18	4,304,177,490.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,391,861.48	175,806,956.52
210101	Үндсэн цалин	170,391,861.48	175,806,956.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,241,363.63	21,975,869.57
210201	Тэтгэврийн даатгал	21,241,363.63	21,975,869.57
2104	Хангамж, бараа материалын зардал	6,135,111.37	5,031,091.32
210401	Бичиг хэрэг	1,691,200.00	1,094,300.00
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,546,411.37	3,936,791.32
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	147,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,800,000.00
210604	Урсгал засвар	-	4,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,231,690,374.70	4,096,563,572.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,212,604,652.95	4,078,532,409.78
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,000,000.00	17,600,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	85,721.75	431,163.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	353,021,531.48	3,194,803,041.00
2200	Дотоод эх үүсвэрээс	353,021,531.48	3,194,803,041.00
225012	Тоног төхөөрөмж	353,021,531.48	3,194,803,041.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,585,423,942.98	(1,467,208,561.89)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	170,309,038.66	48,760,386.05
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	170,309,038.66	48,760,386.05
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	27,947,804.78
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	27,947,804.78
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,755,732,981.63	(1,446,395,980.62)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,082,083,532.34	4,930,637,570.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,082,083,532.34	4,930,637,570.41
120	Нийтлэг татварын бус орлого	1,082,083,532.34	4,930,637,570.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,082,083,532.34	4,930,637,570.41
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,081,883,532.34	4,930,637,570.41
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	733,363,108.48	3,826,523,017.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	733,363,108.48	3,826,523,017.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	733,363,108.48	3,826,523,017.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,391,861.48	175,806,956.53
210101	Үндсэн цалин	170,391,861.48	175,806,956.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,298,982.68	21,918,250.52
210201	Тэтгэврийн даатгал	21,298,982.68	21,918,250.52
2104	Хангамж, бараа материалын зардал	7,427,611.37	11,709,491.32
210401	Бичиг хэрэг	1,691,200.00	1,094,300.00
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,546,411.37	3,936,791.32
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,440,000.00	6,678,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,800,000.00
210604	Урсгал засвар	-	4,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	534,244,652.95	3,612,288,319.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	515,244,652.95	3,594,688,319.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,000,000.00	17,600,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	348,720,423.86	1,104,114,552.96
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	319,480,304.10	71,593,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	319,480,304.10	71,593,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	319,480,304.10	71,593,000.00
222001	Тоног төхөөрөмж	319,480,304.10	71,593,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(319,480,304.10)	(71,593,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	169,300,310.03	11,150,943.99
14	Бусад эх үүсвэр	169,300,310.03	38,819,338.75
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	169,300,310.03	38,819,338.75
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	27,668,394.76
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	27,668,394.76
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	198,540,429.79	1,043,672,496.95
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,264,743,285.84	1,463,283,715.63
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,463,283,715.63	2,506,956,212.58

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,265,402,764.84	1,265,402,764.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,265,402,764.84	1,265,402,764.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,755,732,981.63	2,755,732,981.64
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	4,021,135,746.47	4,021,135,746.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(1,446,395,980.62)	(1,446,395,980.62)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,446,395,980.62)	(1,446,395,980.62)
2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	2,574,739,765.85	2,574,739,765.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,664,714,800.00	4,537,076,625.65	127,638,174.35	97.3
УРСГАЛ ЗАРДАЛ	3,954,114,800.00	3,826,523,017.45	127,591,782.55	96.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,954,114,800.00	3,826,523,017.45	127,591,782.55	96.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,290,000.00	175,806,956.53	15,483,043.47	91.9
Үндсэн цалин	191,290,000.00	175,806,956.53	15,483,043.47	91.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,105,000.00	21,918,250.52	2,186,749.48	90.9
Тэтгэврийн даатгал	24,105,000.00	21,918,250.52	2,186,749.48	90.9
Хангамж, бараа материалын зардал	14,946,000.00	11,709,491.32	3,236,508.68	78.3
Бичиг хэрэг	2,825,000.00	1,094,300.00	1,730,700.00	38.7
Тээвэр, шатахуун	1,500,000.00	-	1,500,000.00	-
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,941,000.00	3,936,791.32	4,208.68	99.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,680,000.00	6,678,400.00	1,600.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	4,800,000.00	4,800,000.00	0.00	100.0
Урсгал засвар	4,800,000.00	4,800,000.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,718,973,800.00	3,612,288,319.08	106,685,480.92	97.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,701,373,800.00	3,594,588,319.08	106,785,480.92	97.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	17,600,000.00	17,600,000.00	0.00	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	710,600,00.00	710,553,608.20	46,391.80	100.0
Тоног төхөөрөмж	710,600,00.00	710,553,608.20	46,391.80	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,664,714,800.00	5,569,598,178.61	(904,883,378.61)	119.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,664,714,800.00	5,569,598,178.61	(904,883,378.61)	119.4
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,664,714,800.00	5,569,598,178.61	(904,883,378.61)	119.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,463,283,715.63		
Төсвийн тохируулга		11,150,943.99		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,506,956,212.58		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	5	5		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	4	4		100.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 12,222,993.4 мянган төгрөгийн нийт 166 мэдээллээс 9,035,293.2 мянган төгрөгийн 164 мэдээллийг хугацаанд нь байршуулж, дараа жилийн төсвийн төслийн 3,170,100.2 мянган төгрөгийн 1 гүйлгээ, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 17,600.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулсан байна.	1	3,187,700.2	1	3,187,700.2	-	-
Дүн	1	3,187,700.2	1	3,187,700.2	-	-